



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 401

Улаанбаатар хот

Г “Хэрэглээ импекс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой 7
хувьцаа эзэмшигчдээс гаргасан тендер саналыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хэрэглээ импекс” ХК-ийн нийт гаргасан 53,000 ширхэг хувьцааны 69,86 хувь буюу 37,031 ширхэг хувьцааг нэгдмэл сонирхолтойгоор “Экспонинциал фонд менежмент” ХХК, иргэн Б.Болдбаатар нар эзэмшдэг ба тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцаа нэг бүрийг нь 1,385 /нэг мянга гурван зуун наян тав/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авч тендер санал гаргасныг зөвшөөрч, хүчинтэй байх хугацааг 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу “ҮЦГТТХТ” ХХК-тай гэрээ байгуулж мөнгөн хөрөнгийг байршуулж, тендер саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, тендер саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногийн дотор тендер саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүд/Б.Батхүү/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН